



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/2022

Чойбалсан

Г Тусгай зөвшөөрөл олгох тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.5, 19.18 дэх заалтууд, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2022 оны гуравдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүслийн хайрхан уул” ХХК-ийн “Гурван хүсэл” үүдэн эмнэлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа “Согтуурах донтой хүнийг албадан эмчлэх эмнэлэг”, “Арвижих цагаан тан” ХХК-ийн “Арвижих тан” эмийн сан (2 дугаар зэрэглэл), “Фөрст эйд кит” ХХК-ийн “Venus” (2 дугаар зэрэглэл) эмийн санд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 3 жилийн хугацаагаар олгож, хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг “Хүслийн хайрхан уул” ХХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа “Согтуурах, мансуурах донтой хүний албадан эмчлэх эмнэлэг”, “Арвижих цагаан тан” ХХК, “Фөрст эйд кит” ХХК-ийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН



0101 1915

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	Олгосон хугацаа	Хүчинтэй хугацаа	
						Эхлэх	Дуу-сах
1	Хүслийн хайрхан уул” ХХК”	“Гурван хүсэл” үүдэн эмнэлэг	Хэрлэн сум 7-р баг Маршал хотхон 46В байр тоот	Чих, хамар, хоолойн үзлэг, оношилгоо, эмчилгээ	3 жил	2022.12.16	2025.12.16
2	ШШГГазар	ШШГГ-ын харьяа Согтуурах донтой хүнийг албадан эмчлэх эмнэлэг	Хэрлэн сум, 1 дүгээр баг Албадан эмчилгээний төвийн байр	Согтуурах донтой хүнийг албадан хэвтүүлэн эмчлэх	3 жил	2022.12.16	2025.12.16
3	“Арвижих цагаан тан” ХХК	“Арвижих тан” эмийн сан”	Хэрлэн сум, 1 дүгээр баг мал эмнэлгийн зүүн талд төв зам дагуу 2 давхар байр	Эм барих, худалдах /2 дугаар зэрэглэл/	3 жил	2022.12.16	2025.12.16
4	“Фөрст эйд кид” ХХК	“Venus” эмийн сан	Хэрлэн сум, 7 дугаар баг, Үйлчилгээний төвийн хойно Этүгэн эм эмнэлгийн 1 давхарт	Эм барих, худалдах /2 дугаар зэрэглэл/	3 жил	2022.12.16	2025.12.16

Аймгийн Засаг даргын 2022 оны
 дугаар сарын 16-ны өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРҮҮЛ
 МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	Олгосон хугацаа	Хүчинтэй хугацаа	
						Эхлэх	Дуусгах
1	Хүслийн хайрхан уул" ХХК"	"Гурван хүсэл" үүдэн эмнэлэг	Хэрлэн сум 7-р баг Маршал хотхон 46В байр тоот	Чих, хамар, хоолойн үзлэг, оношилгоо, эмчилгээ	3 жил	2022.12.16	2025.12.16
2	ШШГГазар	ШШГГ-ын харъяа Согтуурах донтой хүнийг албадан эмчлэх эмнэлэг	Хэрлэн сум, 1 дүгээр баг Албадан эмчилгээний төвийн байр	Согтуурах донтой хүнийг албадан хэвтүүлэн эмчлэх	3 жил	2022.12.16	2025.12.16
3	"Арвижих цагаан тан" ХХК	"Арвижих тан" эмийн сан	Хэрлэн сум, 1 дүгээр баг мал эмнэлгийн зүүн талд төв зам дагуу 2 давхар байр	Эм барих, худалдах /2 дугаар зэрэглэл/	3 жил	2022.12.16	2025.12.16
4	"Ферст эйд кид" ХХК	"Venus" эмийн сан	Хэрлэн сум, 7 дугаар баг, Үйлчилгээний төвийн хойно Этүгэн эм эмнэлгийн 1 давхарт	Эм барих, худалдах /2 дугаар зэрэглэл/	3 жил	2022.12.16	2025.12.16